



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4203

2026.02.25 № 146
танай 2026.01.23 -ны № 35 -Т

БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН
ДАРГА Ч.АРИУНАА ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу танай байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, санал дүгнэлтийг хүргүүлж байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллаж, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ирүүлэх.

Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг тогтоосон хугацаанд ирүүлнэ үү.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

2120070141





ДОРНОД АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН
ГАЗРЫН ДАРГА Ч.АРИУНАА ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг. 21000
Утас: 7058-4203

2026.02.25 № 144

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Боловсролын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дорнод аймгийн Боловсролын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн, нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Боловсролын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг дарга 95.0 хувиар үнэлж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

2126050065

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 30 АНТӨЗ10 ДАА-2026/123/НА-СТА-ТМЗ Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сум орон нутагт эхний таван жил болон дараагийн гурван жил ажилласан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн 396 ажилтанд 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжид олгосон 3,299.4 сая төгрөгөөс хувь хүний орлогын албан татвар 329.9 сая төгрөгийг суутган төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.19-д "суутган төлөгч" гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: 6.3.1.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна" 7.1.1-д ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 25 дугаар зүйлийн 25.1.1-д "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх";, 25.6-д "Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг таслан зогсоож, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-д заасан мөнгөн тэтгэмжээс хувь хүний орлогын албан татварыг суутган тооцох.

2126090034

2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Боловсролын газрын дарга Ч.Ариунаа, нягтлан бодогч Д.Балжинням нарт хариуцуулав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.НАРМАНДАХ

АУДИТОР



С.ЭНХБААТАР





ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ДОА-2026/123/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2026 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn Аудитор: С.Энхбаатар Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3-4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	112
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	112
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	112
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	13
3.5.3 Нэмэлт төсөв	13
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
4.5 Ерөнхий чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорил, судалгааны үр дүн.....	15
4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.6.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН
ГАЗРЫН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгорын аудал, 8 дугаар баг
Хяалган сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7559-4203

2025.02.25 № 114

Тайлангийн №: _____

ДОРНОД АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН
ГАЗРЫН ДАРГА Ч.АРИУНАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Боловсролын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дорнод аймгийн Боловсролын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хиихдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн, нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Боловсролын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг дарга 95.0 хувиар үнэлж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

2126050065

Дорнод аймгийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь захиран эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
33	АВЛАГА	0.00	15,309,705.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	15,309,705.00
35	БАРАА МАТЕРИАЛ	68,984,243.40	48,344,039.40
354	Хангамжийн материал	68,984,243.40	48,344,039.40
35410	Бичиг хэргийн материал	105,400.00	0.00
35420	Аж ахуйн материал	1,637,500.00	1,527,000.00
35470	Бусад хангамжийн материал	67,241,343.40	46,817,039.40
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	68,984,243.40	63,653,744.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,494,740,706.94	2,573,356,691.30
392	Биет хөрөнгө	1,216,455,706.94	1,298,071,691.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,245,253,882.00	1,245,253,882.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-184,738,560.02	-205,492,791.38
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	157,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-9,158,333.31
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	464,676,300.99	467,512,700.99
39206	Хуримтлагдсан элэгдэл	-315,254,998.67	-361,357,923.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,777,015.90	48,777,015.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,257,933.26	-44,462,859.50
393	Биет бус хөрөнгө	1,278,285,000.00	1,275,285,000.00
39301	Програм хангамж	18,750,000.00	18,750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,750,000.00	-6,750,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,263,285,000.00	1,263,285,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,494,740,706.94	2,573,356,691.30
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,563,724,950.34	2,637,010,435.70
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
51	Засгийн газрын хувь оролцоо	2,563,724,950.34	2,637,010,435.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,456,878,243.20	1,456,878,243.20
51101	Өмч: - төрийн	1,456,878,243.20	1,456,878,243.20
512	Хуримтлагдсан үр дүн	1,103,379,411.11	1,176,664,896.47
51210	Өмнөх үеийн үр дүн	1,140,072,645.02	1,103,379,411.11
51220	Тайлант үеийн үр дүн	-36,693,233.91	73,285,485.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,467,296.03	3,467,296.03
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,563,724,950.34	2,637,010,435.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,563,724,950.34	2,637,010,435.70

Дорнод аймгийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,198,230,997.00	7,386,454,025.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,717,793,900.00	6,012,248,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,717,793,900.00	6,012,248,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,480,437,097.00	1,374,205,325.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,324,309,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,480,437,097.00	49,895,425.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	121,461,066.00	159,066,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	121,461,066.00	159,066,400.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	14,694,786.00	159,066,400.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	106,766,280.00	0.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,319,692,063.00	7,545,520,425.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,356,385,296.91	7,472,234,939.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,989,046,239.50	1,764,677,516.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	837,613,116.66	911,392,097.98
210101	Үндсэн цалин	415,259,458.66	417,270,337.74
210102	Нэмэгдэл	293,043,352.00	345,646,287.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	72,270,246.00	90,350,611.00
210104	Урамшуулал	57,040,060.00	58,124,861.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,993,772.67	112,773,043.36
210201	Тэтгэврийн даатгал	71,207,282.48	76,744,995.23
210202	Тэтгэмжийн даатгал	8,731,462.79	9,089,348.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,485,141.41	4,544,824.26
210204	Ажилгүйдлийн даатгал	4,218,909.21	4,501,875.08
210205	Эрүүл мэндийн даатгал	17,350,976.78	17,892,000.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,132,531.86	10,956,808.86
210301	Гэрэл, цахилгаан	4,114,351.37	4,005,929.17
210302	Түлш, халаалт	3,967,944.49	4,495,423.69
210303	Цэвэр, бохир ус	3,050,236.00	2,455,456.00
2104	Хангамж, бараа материалын зардал	73,783,250.00	30,964,290.00
210401	Бичиг хэрэг	2,750,650.00	1,361,200.00
210402	Тээвэр, шатахуун	7,910,000.00	4,776,686.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,382,550.00	2,363,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,067,770.00	1,403,450.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	21,059,204.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	59,672,280.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	3,134,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	3,134,000.00	0.00

Дорнод аймгийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	630,938,992.40	530,187,046.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	630,938,992.40	529,851,016.00
210807	Газрын төлбөр	0.00	150,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	186,030.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	326,450,575.91	168,404,230.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,828,500.00	7,119,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	197,985,006.00	80,064,465.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,637,069.91	81,220,415.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,367,339,057.41	5,707,557,422.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,790,738,153.50	5,575,796,703.29
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,407,952,153.50	1,595,678,703.29
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,760,225,500.00	3,299,418,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	622,560,500.00	680,700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	576,600,903.91	131,760,719.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	574,418,376.31	116,376,770.51
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,182,527.60	15,383,949.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,356,385,296.91	7,472,234,939.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-36,693,233.91	73,285,485.36
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-36,693,233.91	73,285,485.36

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,198,230,997.00	7,386,454,025.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,717,793,900.00	6,012,248,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,717,793,900.00	6,012,248,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,480,437,097.00	1,374,205,325.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,324,309,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,480,437,097.00	49,895,425.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	9,198,230,997.00	7,386,454,025.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,179,931,097.00	7,385,684,025.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,812,592,039.59	1,678,126,602.20

Дорнод аймгийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	837,613,116.66	911,392,097.98
210101	Үндсэн цалин	415,259,458.66	417,270,337.74
210102	Нэмэгдэл	293,043,352.00	345,646,287.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	72,270,246.00	90,350,611.00
210104	Урамшуулал	57,040,060.00	58,124,861.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,993,772.67	112,773,043.36
210201	Тэтгэврийн даатгал	71,207,282.48	76,744,995.23
210202	Тэтгэмжийн даатгал	8,731,462.79	9,089,348.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,485,141.41	4,544,824.26
210204	Ажилгүйдлийн даатгал	4,218,909.21	4,501,875.08
210205	Эрүүл мэндийн даатгал	17,350,976.78	17,892,000.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,132,531.86	10,956,808.86
210301	Гэрэл, цахилгаан	4,114,351.37	4,005,929.17
210302	Түлш, халаалт	3,967,944.49	4,495,423.69
210303	Цэвэр, бохир ус	3,050,236.00	2,455,456.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,830,120.00	10,024,086.00
210401	Бичиг хэрэг	2,647,800.00	1,361,200.00
210402	Тээвэр, шатахуун	7,500,000.00	4,776,686.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,382,550.00	2,363,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,299,770.00	1,522,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	260,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	260,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,134,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	3,134,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	630,938,992.40	545,496,751.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	630,938,992.40	545,160,721.00
210807	Газрын төлбөр	0.00	150,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	186,030.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	209,949,506.00	87,223,815.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,964,500.00	7,119,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	197,985,006.00	80,104,465.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,367,339,057.41	5,707,557,422.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,790,738,153.50	5,575,796,703.29
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,407,952,153.50	1,595,678,703.29
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,760,225,500.00	3,299,418,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	622,560,500.00	680,700,000.00

Дорнод аймгийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	576,600,903.91	131,760,719.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	574,418,376.31	116,376,770.51
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,182,527.60	15,383,949.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)	<u>9,179,931,097.00</u>	<u>7,385,684,025.00</u>
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>18,299,900.00</u>	<u>770,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,299,900.00	770,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,299,900.00	770,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,299,900.00	770,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	18,299,900.00	770,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-18,299,900.00</u>	<u>-770,000.00</u>
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцсон нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,053,853,243.20	3,467,296.03	1,140,072,645.02	2,197,393,184.25
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,053,853,243.20	3,467,296.03	1,140,072,645.02	2,197,393,184.25
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	403,025,000.00	0.00	0.00	403,025,000.00
C09	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-36,693,233.91	-36,693,233.91
C10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,456,878,243.20	3,467,296.03	1,103,379,411.11	2,563,724,950.34
C11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,456,878,243.20	3,467,296.03	1,103,379,411.11	2,563,724,950.34
C12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,456,878,243.20	3,467,296.03	1,103,379,411.11	2,563,724,950.34
C19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	73,285,485.36	73,285,485.36
C20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,456,878,243.20	3,467,296.03	1,176,664,896.47	2,637,010,435.70

Дорнод аймгийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
12200	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,017,170,300.00	6,012,248,700.00
122005	Төсвөөс санхүүжих	6,017,170,300.00	6,012,248,700.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	6,017,170,300.00	6,012,248,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,017,170,300.00	6,012,248,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,026,687,700.00	1,000,775,226.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	848,453,300.00	848,453,297.98
210101	Үндсэн цалин	438,003,300.00	417,270,337.74
210102	Нэмэгдэл	308,368,900.00	282,707,487.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,512,800.00	90,350,611.00
210104	Урамшуулал	49,568,300.00	58,124,861.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,342,400.00	106,259,943.36
210201	Тэтгэврийн даатгал	73,029,500.00	72,236,087.23
210202	Тэтгэмжийн даатгал	8,591,700.00	8,588,300.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,295,700.00	4,294,300.26
210204	Ажилгүйдлийн даатгал	4,285,100.00	4,251,351.08
210205	Эрүүл мэндийн даатгал	17,140,400.00	16,889,904.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,025,000.00	10,956,808.86
210301	Гэрэл, цахилгаан	5,589,000.00	4,005,929.17
210302	Түлш, халаалт	4,819,500.00	4,495,423.69
210303	Цэвэр, бохир ус	1,616,500.00	2,455,456.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,558,400.00	10,024,086.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,361,200.00
210402	Тээвэр, шатахуун	4,500,000.00	4,776,686.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,232,000.00	2,363,750.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,935,900.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,690,500.00	1,522,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,030,000.00	1,030,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,030,000.00	1,030,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,182,300.00	9,473,120.00
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	23,099,000.00	9,137,090.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	322,500.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	35,800.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	31,400.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,700.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,164,700.00	0.00

Дорнод аймгийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр, хураамж	269,500.00	150,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	895,900.00	186,030.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,343,800.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,096,300.00	14,577,970.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,119,400.00	7,119,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,976,900.00	7,458,620.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,990,482,600.00	5,011,473,473.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,990,482,600.00	4,895,096,703.29
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,667,642,400.00	1,595,678,703.29
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,322,840,200.00	3,299,418,000.00
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	116,376,770.51
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	116,376,770.51

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /төгрөгөөр/
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,374,205,325.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,374,205,325.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	678,121,376.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62,938,800.00
210102	Нэмэгдэл	62,938,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,513,100.00
210201	Тэтгэврийн даатгал	4,508,908.00
210202	Тэтгэмжийн даатгал	501,048.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	250,524.00
210204	Ажилгүйдлийн даатгал	250,524.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,002,096.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	536,023,631.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	536,023,631.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,645,845.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	72,645,845.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	696,083,949.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	680,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	680,700,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,383,949.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	15,383,949.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,374,205,325.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,374,205,325.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,324,309,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,895,425.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорнод аймгийн Боловсролын газар нь боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хичээл, судлагдахууны агуулга, арга зүй, үнэлгээ, технологи болон зайн, цахим сургалтыг хөгжүүлэх, сургалтын чанар, үр дүнг сайжруулах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, иргэнд боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах, насан туршдаа суралцахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсролын газар нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 73.3 сая төгрөгөөр буюу 2.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	15,309.7	15,309.7
Бараа материал	68,984.2	48,344.0	(20,640.2)
Үндсэн хөрөнгө	2,494,740.7	2,573,356.7	78,616.0
Нийт хөрөнгө	2,563,724.9	2,637,010.4	73,285.5
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,563,724.9	2,637,010.4	73,285.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,563,724.9	2,637,010.4	73,285.5

Авлагын дансны үлдэгдэл 15.3 сая төгрөг байгаа нь эцэст Боловсролын үнэлгээний төвөөс нэмэлт санхүүжилт орж ирснийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 48.3 сая төгрөг болж өмнөх оноос 20.6 сая төгрөгөөр буурсан нь бараа материал ахталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,573.4 сая төгрөг болж өмнөх оноос 78.0 сая төгрөгөөр өссөн нь дээд шатны байгууллагаас үндсэн хөрөнгө хандив тусламжаар хүлээн авсантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 73.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг 7,145.0 сая төгрөгөөр тооцож, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 7,145.0 сая төгрөг байхаар дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Цалингийн зардлыг батлагдсан орон тоо буюу 34 орон тоогоор тооцож төсвийн төсөлд тусгасан бөгөөд төсвийг батлахдаа 27 орон тоотой байхаар цалин зардлыг бууруулж, нийт зардлыг 6,540.5 сая төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,540.5 сая төгрөгөөр баталсан байна.

Батлагдсан төсвийн нийт зардлыг 523.4 сая төгрөгөөр бууруулж, 6,017.2 сая төгрөг болгон тодотгол хийсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,012.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,895.9 сая төгрөг буюу 98.0 хувьтай байна. Олгосон санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдэл болох 116.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,021,766.0	1,000,775.2	20,990.8	98%
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	4,990,482.6	4,895,096.7	95,385.9	98%
	Нийт дүн	6,012,248.6	5,895,871.9	116,376.7	98%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд орон нутгийн төсөв болон дээд шатны төсвийн захирагчаас 1,374.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч үүнээс цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-д 69.5 сая төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 536.0 сая төгрөгийг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 72.6 сая төгрөгийг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 680.7 сая төгрөгийг тус тус зарцуулж, 15.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын хүрээнд батлагдсан төсвөөс шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаараас хэтэрсэн зардал байхгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Боловсролын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Энхбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нармандах, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар хэрэгжүүлсэн.

Боловсролын газар 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 7,485.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 74.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын гүйцэтгэлийн явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хүрээнд тус байгууллага нь хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаагүй, үр дүн гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Ерөнхий чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорил, судалгааны үр дүн

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн 8 судалгаанаас дараах 3 нь хамааралтай байна. Үүнд:

1. *Хоол унааны хөнгөлөлтийн судалгаа:* Боловсролын газрын даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар хоолны мөнгийг өдрийн 20.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна. Тайлант онд нийт 90.4 сая төгрөгийн хоолны мөнгө олгосон байна.
2. *Программ хангамжийн судалгаа:* Оны эхэнд 18.8 сая төгрөгийн программ бүртгэлтэй байснаас 0.8 сая төгрөгийн 2 программыг эрх бүхий байгууллагын шийдвэрээр бүртгэл тайлангаас хассан /акталсан/ байна.
3. *Орон тооны цомхотголын судалгаа:* Боловсролын сайдын 2024 оны А/30 дугаар тушаалаар аймгийн Боловсролын газрыг 34 орон тоотой байхаар баталсан байна. Тайлант онд 26 орон тоотой ажилласнаас төрийн захиргааны албан хаагч 27, төрийн үйлчилгээний албан хаагч 7 байна.

4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.6.1 Завсрын аудитын талаар

Боловсролын газрын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгдээгүй.

4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар цалингийн урамшуулалтай холбоотой 1 албан шаардлага, бүртгэл тайлагналтай холбоотой 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Албан шаардлага	2	12,833.0	2	12,833.0	100.0
Зөвлөмж	2	129,375.1	2	129,375.1	100.0
Дүн	4	142,208.1	4	142,208.1	100.0

4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт 5, 3 жил тасралтгүй ажилласан албан хаагчдад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид ХХОАТ суутган тооцсон эсэхийг анхаарч авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 71.8 сая төгрөгийн алдаа¹ илэрсэнд аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

Залруулсан алдаа:

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 71.8 сая төгрөгийн хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр данс бүртгэлээс хассан /акталсан/ нь санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 329.9 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 329.9 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгч ажиллалаа.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 329.9 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 255.1 сая төгрөгөөр давсан ч материаллаг бус нийцлийн аудитын асуудал тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.2 Албан шаардлага

Сум орон нутагт эхний таван жил болон дараагийн гурван жил ажилласан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн 396 ажилтанд 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжид олгосон 3,299.4 сая төгрөгөөс хувь хүний орлогын албан татвар 329.9 сая төгрөгийг суутган тооцоогүй байна. Энэ Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.19-д "суутган төлөгч" гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: 6.3.1.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна" 7.1.1-д ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 25 дугаар зүйлийн 25.1.1-д "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;", 25.6-д "Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Дорнод аймгийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын батлагдсан орон тоо нь 2026 онд өөрчлөгдөөгүй хэвээр байна. Энэ нь Монгол Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл"-д "Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон тоог бууруулах арга хэмжээ авч ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Зохих шийдвэргүй үндсэн хөрөнгө акталсан	1	71,840.9			1	71,840.9						
Дүн	1	71,840.9			1	71,840.9						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орон тоог 9 хувиар бууруулаагүй	1	0.0					1	0.0				
Дүн	1	0.0					1	0.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Мөнгөн тэтгэмжээс хуулийн дагуу ХХОАТ суутган тооцоогүй.	1	329,941.8					1	329,941.8				
Дүн	1	329,941.8					1	329,941.8				